



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/440

Улаанбаатар хот

Амьжиргааны зардлын хэмжээг
шинэчлэн батлах тухай

Боловсролын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь заалт, Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 215 дугаар тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээл эргэн төлүүлэх журам”-ын 1.3.8, 1.6 дахь заалт, ГХЯ-ны 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01/494 тоот албан бичиг “Хилийн чанад дахь Монгол оюутнуудын амьжиргааны зардлын судалгаа”, Боловсролын зээлийн сангийн 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 01/414 тоот албан бичгээр ирүүлсэн “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцах суралцагчдад олгох амьжиргааны зардлын санал”-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад тэтгэлэг, буцалтгүй тусламжаар суралцагчдад Боловсролын зээлийн сангаас 2025-2026 оны хичээлийн жилд олгох амьжиргааны зардлын хэмжээг хавсралтад зааснаар шинэчлэн баталсугай.

2. Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад тэтгэлэг, буцалтгүй тусламжаар суралцагчид нь тухайн сургуулийн дотуур байранд байрлах тохиолдолд сургуулийн нэхэмжлэлийн дүнгээр, бусад тохиолдолд хавсралтад заасан хэмжээгээр тооцон зардлыг олгосугай.

3. Тушаалын хэрэгжилтийг ханган, хяналт тавьж ажиллахыг Гадаад, хамтын ажиллагааны газар /Б.Энхбаяр/, Боловсролын зээлийн сан /О.Сийлэгмаа/-д, төсвийн хуваарьт зохицуулалт хийхийг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /С.Должинсүрэн/-д тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/548 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



П.НАРАНБАЯР

14251 1233

Боловсрол сайдын 2025 оны 09
дугаар сарын 10 ны өдрийн
тушаалын хавсралт

АМЬЖИРГААНЫ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ

ATA12937 9116621 9024070582

№	Улс	Хүнсний зардал (USD/сар)	Хүнсний зардал (USD/сар) 2026 оны 01 сарын 01-нээс	Дотуур байрны зардал (USD/жил)
1.	Австрали	400	440	19,855.50 USD
2.	Их Британи	400	440	22,086.12 USD
3.	Герман	400	440	3,990.00 EUR
4.	Франц	400	440	6,300.00 EUR
5.	Орос	200	220	6,615.00 USD
6.	Польш	400	440	945.00 EUR
7.	Румын	400	440	
8.	Унгар	400	440	3,519.60 EUR
9.	Чех	400	440	3,351.00 EUR
10.	Канад	400	440	11,235.00 USD
11.	АНУ	400	440	15,750.00 USD
12.	Австри	400	440	1,735.00 EUR
13.	Солонгос	400	440	1,1697.76 USD
14.	Япон	400	440	2409.36 USD
15.	Хятад	200	220	2,788.00 USD
16.	Вьетнам	200	220	
17.	Лаос	200	220	
18.	Литва	200	220	1,260.00 EUR
19.	Тайвань (БНХАУ)	400	440	
20.	Энэтхэг	200	220	2,310.00 USD
21.	Казахстан	200	220	
22.	Болгар	200	220	
23.	Беларусь	200	220	
24.	Тайланд	200	220	
25.	Куба	200	220	
26.	Өвөрмонгол (БНХАУ)	200	220	
27.	Турк	400	440	3,519.60 EUR

Тайлбар: Гадаад харилцааны яамнаас ирүүлсэн судалгаа болон
Боловсролын зээлийн сангийн саналыг үндэслэн боловсруулав.